



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/15

Ховд

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн сахиул С.Лувсандоржийн аав хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн тул байгууллага хамт олноос эмгэнэл илэрхийлж, 250000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2. С.Лувсандоржид буцалтгүй тусламжийн зардлаас 250000 төгрөг /хоёр зуун тавин мянган/-ийн тусламж үзүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД